



БАГАНУУР ДҮҮРГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



---

Танаа

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ,  
НИЙГМИЙН БАЙДАЛ

/2016 оны эхний хагас жил/

/албан ёсны статистик мэдээллээр бэлтгэсэн танилцуулга/

## ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Хүснэгт 1. 2015 оны жилийн эцсийн байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	1 хороо	2 хороо	3 хороо	4 хороо	5 хороо	Дүүргийн дүн
Өрхийн тоо	Тоо	2575	216	2306	1426	1939	8462
Суурин хүн ам	Тоо	8423	644	7832	5154	6366	28419
Үүнээс: эрэгтэй	Тоо	4064	321	3803	2534	3133	13855
эмэгтэй	Тоо	4359	323	4029	2620	3233	14564
Малын тоо	Тоо	39899	9845	42554	40806	21879	154983
Үүнээс: Тэмээ	Тоо	65	-	135	3	-	203
Адуу	Тоо	3438	584	2755	2716	2172	11665
Үхэр	Тоо	3156	1209	3208	2908	1838	12319
Хонь	Тоо	19895	4588	22580	21840	11200	80103
Ямаа	Тоо	13345	3464	13876	13339	6669	50693

## Хүснэгт 2. Жил бүрийн тайлант хугацаанд


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Суурин хүн ам	Тоо	25875	26905	27036	27440	27936	28333	28419	-
Төрөлт	Тоо	365	324	282	351	393	369	350	305
Нас баралт	Тоо	81	84	93	77	92	90	95	76
Шилжиж ирсэн	Тоо	451	701	422	304	461	496	508	515
Шилжиж явсан	Тоо	754	829	459	377	447	495	596	601
Ажилгүйчүүд	Тоо	501	648	512	466	544	397	412	602
Халдварт өвчин	Тоо	283	271	288	311	326	217	374	597
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	155	145	134	153	151	120	159	152

**АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2016 оны эхний хагас жилийн байдлаар 51.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2.7 хувиар буюу 1.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.


Хүснэгт 3. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Үзүүлэлт	Нийт үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/			Нийт үйлдвэрлэлт /үнийн дүнгээр, мянган төгрөг/		
	2015 он	2016 он	өсөлт бууралт	2015 он	2016 он	өсөлт бууралт
Нүүрс олборлолт	1731.0	1776.8	45.8	45513675.0	48862000.0	3348325.0
Дулаан дамжуулалт	81.6	81.6	0.0	2254110.3	2539431.3	285321.0
Талх үйлдвэрлэлт	59.2	66.4	7.2	74522.9	83889.4	9366.5
Нарийн боов үйлдвэрлэлт	87.4	70.7	-16.7	193912.3	154554.3	-39358.0
Арматур	6100.0	-	-	5063000.0	-	-

Зураг 1. Нүүрс олборлолт /сараар/



Зураг 2. Нүүрс олборлолт /мян.тонн/



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 2.6 хувиар буюу 45.8 мянган тонноор, талх үйлдвэрлэл 12.2 хувиар буюу 7.2 тонноор тус тус нэмэгдэж, нарийн боов үйлдвэрлэл 19.1 хувиар буюу 16.7 тонноор буурсан бол дулаан дамжуулалт өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд байна. Тайлант хугацаанд арматур үйлдвэрлэгдээгүй байна.

Зураг 3. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, тонн



Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /үнийн дүнгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 7.4 хувиар буюу 3348.3 сая төгрөгөөр, дулаан дамжуулалт 12.7 хувиар буюу 285.3 сая төгрөгөөр, талх үйлдвэрлэлт 12.6 хувиар буюу 9.4 сая төгрөгөөр тус тус өссөн бол нарийн боов үйлдвэрлэлт 20.3 хувиар буюу 39.4 сая төгрөгөөр буурсан байна.

**МАЛ АЖ АХУЙ:** 2016 оны эхний хагас жилийн байдлаар дүүрэгт 662 том мал зүй бусаар хорогдсон ба үүний 84 толгой нь хээлтэгч мал байна. Тайлант хугацаанд хорогдсон мал нь өнгөрсөн онд тоологдсон нийт малын 0.4 хувийг эзэлж байна. Мөн нийт хорогдсон малын 28 толгой мал өвчнөөр хорогдсон байна.

Хүснэгт 4. Том малын зүй бус хорогдол /хороогоор/

	Нийт хорогдол	Үүнээс:				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1 хороо	47	-	-	-	25	22
2 хороо	136	-	17	26	55	38
3 хороо	345	-	13	67	136	129
4 хороо	66	-	5	8	22	31
5 хороо	68	-	-	4	29	35
Дүүргийн дүн	662	-	35	105	267	255

Хүснэгт 5. Мал төллөлт, төл бойжилт

	Бүгд	Үүнээс:				
		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
Төллөсөн хээлтэгч	64088	21	3076	4092	34690	22209
Гарсан төл	64107	21	3076	4092	34696	22222
Хорогдсон төл	551	-	22	29	223	277
Бойжсон төл	63556	21	3054	4063	34473	21945
Төл бойжилт /хувь/	99.1	100.0	99.3	99.3	99.4	98.8

2016 оны эхний хагас жилийн байдлаар 64088 толгой эх мал төллөж 64107 төл гарснаас 551 толгой төл мал хорогдсон байна. Энэ нь нийт гарсан төлийн 0.8 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд 63556 толгой төл мал бойжиж байгаа бөгөөд төл бойжилт 99.1 хувьтай байна. Мал тооллогын дүнгээр энэ онд 72091 толгой төллөх насны хээлтэгч төллөхөөс 64088 эх мал төллөсөн байгаа нь 89.0 хувьтай байна.

**ТЭЭВЭР:** 2016 оны эхний хагас жилийн байдлаар тээврийн салбарын нийт орлого 408.8 сая төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 36.1 хувиар буюу 231.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Тээврийн салбарын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	өсөлт бууралт
Нийт орлого \мян төг\	459572.8	639990.9	408764.0	-231226.9
Тээсэн зорчигч \мян хүн\	137.0	93.9	94.2	0.3
Зорчигч эргэлт \мян хүн км/	18495.0	12676.5	12757.5	81.0

Тайлант хугацаанд авто тээврээр давхардсан тоогоор 12757.5 мянган хүн километр 94.2 мянган зорчигч үйлчлүүлсэн нь өнгөрсөн оноос зорчигч эргэлт 0.6 хувиар буюу 81.0 мянган хүн километрээр, зорчигчдын тоо 0.3 хувиар буюу 0.3 мянган хүнээр нэмэгдсэн байна.

**ШУУДАН ХОЛБОО:** Шуудан холбооны үйлчилгээний орлого 2016 оны эхний хагас жилд 210215.7 мянган төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 8.1 хувиар буюу 18608.2 мянган төгрөгөөр, хүн амаас орсон орлого 110315.4 мянган төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 4.1 хувиар буюу 4738.8 мянган төгрөгөөр тус тус буурчээ . Нийт орлогын 52.5 хувь нь хүн амаас орсон орлого бөгөөд нийт орлогын дүнд эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2.2 пунктээр нэмэгдсэн байна.

**Хүснэгт 7. Холбооны салбарын үзүүлэлтүүд**

Үзүүлэлтүүд	2014 он	2015 он	2016 он	өсөлт бууралт
Нийт орлого	243685.3	228823.9	210215.7	-18608.2
Үүнээс: хүн амаас орсон орлого	133137.1	115054.2	110315.4	-4738.8
Суурин телефон цэг	741	700	699	-1
Үүнээс: айл өрх	327	280	273	-7
ADSL интернэтэд холбогдож буй ААНБ, айл өрх	237	224	270	46
КaTВ-ын хэрэглэгчдийн тоо	2659	1756	1817	61



Тайлант хугацаанд суурин телефон хэрэглэгчдийн тоо 699, кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо 1817, ADSL интернет ашиглах эрхээр интернетэд холбогдож буй байгууллага, айл өрхийн тоо 270-д хүрсэн байна. Нийт суурин телефон хэрэглэгчдийн 39.1 хувь буюу 273 нь айл өрхийн хэрэглэгчид байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.5 хувиар


буюу 7 хэрэглэгчээр буурсан байна.

2016 оны эхний хагас жилд шуудангийн үйлчилгээний салбар 7.4 мянган ширхэг бичиг захидал, 0.8 мянган ширхэг илгээмж, 140.0 мянган ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэсэн байна.

**НИЙГМИЙН ДААТГАЛ:** Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 6214.6 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 28.2 хувиар буюу 1366.2 сая төгрөгөөр, зарлага 10490.3 сая төгрөг болж 7.4 хувиар буюу 726.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 59.8 хувь буюу 3718.2 сая төгрөгийг тэтгэврийн сангаас, 6.7 хувь буюу 417.6 сая төгрөгийг тэтгэмжийн сангаас, 1.7 хувь буюу 103.2 сая төгрөгийг ажилгүйдлийн сангаас, 10.6 хувь буюу 660.0 сая төгрөгийг ҮОМШӨ сангаас, 21.2 хувь буюу 1315.6 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус төвлөрсөн байна.


Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн орлого



Хүснэгт 8. Нийгмийн даатгалын сангийн орлого, зардал

Үзүүлэлт	2015 он		2016 он	
	Хүний тоо	Сая төгрөг	Хүний тоо	Сая төгрөг
Сангийн орлого бүгд		4848.4		6214.6
үүнээс: тэтгэврийн сан		2977.2		3718.2
тэтгэмжийн сан		333.8		417.6
ажилгүйдлийн сан		81.9		103.2
ҮОМШӨ-ний сан		525.4		660.0
ЭМД-ын сан		930.1		1315.6
Сангийн зарлага бүгд		9764.3		10490.3
үүнээс: тэтгэврийн сан	3775	6570.0	3950	7172.6
тэтгэмжийн сан	1415	376.8	1587	400.8
ажилгүйдлийн сан	95	110.6	91	172.8
ҮОМШӨ-ний сан	445	976.8	347	923.2
ЭМД-ын сан	55692	1730.1	54302	1820.9


Зураг 6. Нийгмийн даатгалын сангийн зарлага /хувиар/



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 3950 хүнд 7172.6 сая төгрөгийн тэтгэвэр, 1587 хүнд 400.8 сая төгрөгийн тэтгэмж, 91 хүнд 172.8 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж, 347 хүнд 923.2 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 54302 хүнд 1820.9 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгал тус тус олгосон байна.

**НИЙГМИЙН ХАЛАМЖ:** 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийгмийн халамжийн сангийн орлого 1246.2 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 1.2 хувиар буюу 15.1 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын 330.0 сая төгрөг буюу 26.5 хувь нь улсын төсвөөс, 912.0 сая төгрөг буюу 73.2 хувь нь орон нутгийн төсвөөс, 4.3 сая төгрөг буюу 0.3 хувь нь бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.



Зураг 7. Нийт орлого 1246.2 сая төгрөг

Хүснэгт 9. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал


Үзүүлэлт		2015 он		2016 он	
		Мян төг	Хүний тоо	Мян төг	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого		1231024.8		1246169.3	
Үүнээс:	Улсын төсвөөс	325000.0		330000.0	
	Орон нутгийн төсвөөс	904233.7		911918.0	
	Бусад орлого	1791.1		4251.3	
Нийгмийн халамжийн сангийн зарлага		1163252.3	5740	1193151.7	5893
Тэтгэвэр		364911.6	544	352989.7	510
Тэтгэмж		161191.4	473	200018.9	505
"Алдарт эх" 1 одонтой эхчүүд		150000.0	750	144800.0	724
"Алдарт эх" 2 одонтой эхчүүд		125414.3	1254	129980.0	1299
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж		164213.3	755	154848.1	667
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл		19555.1	20	19420.0	20
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт		92915.1	562	70790.9	822
ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт		30970.6	156	25814.8	131
"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр		45725.0	1190	71402.5	1200
ОНО-д түшиглэсэн халамжийн үйлчилгээ		3936.0	36	12000.0	15
Бусад үйлчилгээ		4419.9		11086.8	

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 510 хүнд 353.0 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 505 хүнд 200.0 сая төгрөгийн тэтгэмж, “Алдарт эх”-ийн одонтой 2023 хүнд 274.7 сая төгрөг, 667 жирэмсэн эхчүүдэд 154.8 сая төгрөгийн тэтгэмж, 20 ахмад дайчин, гавьяат цолтой хүнд 19.4 сая төгрөг, 822 ахмад настанд 70.8 сая төгрөгийн хөнгөлөлт, 131 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 25.8 сая төгрөгийн хөнгөлөлт олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 15 иргэнд 12.0 сая төгрөгийг тус тус олгосон байна.

“Хүнс тэжээл” халамжийн хөтөлбөрийн хүрээнд 1200 иргэнд 71.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:** Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын нийт орлого 826.0 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.6 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр буурсан байна. Нийт орлогын 528.0 сая төгрөг буюу 64.0 хувь нь хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Зураг 8. Орлогын төлөвлөгөөний биелэлт



Хүснэгт 10. Орон сууц нийтийн аж ахуйн орлогын байдал.

мянган төгрөг

Үзүүлэлт	2015 он	2016 он	Өсөлт бууралт
Орон сууц	60055.0	68916.8	8861.8
Ус борлуулалт-бүгд	393750.9	384575.4	-9175.5
үүнээс: хүн амд	234321.3	226706.2	-7615.1
аж ахуйн нэгжид	150962.1	150553.2	-408.9
үйлчилгээний байгууллагад	8467.5	7316.0	-1151.5
Сувагжуулалт	311520.1	302800.4	-8719.7
Бусад	66023.5	69626.5	3603
Дүн	831349.4	825919.1	-5430.3


СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО: 2016 оны эхний 6 сарын байдлаар дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын орлогын төлөвлөгөөний биелэлт доорх байдалтай байна.

Хүснэгт 11. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын байдал. мянган төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
Тавлаг өргөө	41009.7	34116.8	83.2
Маргад өргөө	28200.0	27873.1	98.8
Сод хөгжил	35412.9	32272.8	91.1
Шинэ элч	31573.5	27742.8	87.9
Уурхайчин	25704.0	23969.3	93.3
НИЙТ ДҮН	161900.1	145974.8	90.9

ЭРҮҮЛ МЭНД: Дүүрэгт эхний 6 сарын байдлаар 384 эх амаржиж, 384 хүүхэд төрүүлснээс гадны 101 эх амаржсан байна. Энэ хугацаанд 54062 хүн амбульторын үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 7845 хүнээр буюу 12.6 хувиар буурсан бол, 4207 хүн хэвтэн эмчлүүлсэн байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 410 хүнээр буюу 10.5 хувиар өссөн байна.

Зураг 9. Халдварт өвчин /сараар/



Хүснэгт 12. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2015 он	2016 он	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	148	134	-14
үүнээс:			
Заг хүйтэн	74	52	-22
Тэмбүү	43	43	-
Мөөгөнцөр /кандидоз/	2	10	8
Трихомониаз	27	28	1
Бэлгийн үү /кандилом/	1	1	-



Халамид	1	-	-1
<b>Цочмог халдварт өвчин</b>	<b>224</b>	<b>463</b>	<b>239</b>
Гепатит А	4	2	-2
Цусан суулга	1	-	-1
Салхин цэцэг	164	33	-131
Гахай хавдар	1	-	-1
Корь	18	351	333
Краснух	-	3	3
Улаан эсэргэнэ/скарлатин/	-	3	3
Сепсис	2	-	-2
Хачигт рикеттиоз	1	-	-1
Боом	1	-	-1
Рож	2	1	-1
Гар хөл амны өвчин	9	57	48
Сүрьеэ	21	13	-8
<b>Нийт халдварт өвчин</b>	<b>372</b>	<b>597</b>	<b>225</b>

2016 оны эхний 6 сарын байдлаар халдварт паразит өвчин 134 болж нийт халдварт өвчний 22.4 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 14 тохиолдлоор буюу 9.4 хувиар буурсан бол цочмог халдварт өвчин 463 тохиолдол байгаа нь нийт халдварт өвчний 77.5 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 239 тохиолдлоор буюу 2.1 дахин өссөн байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 210.7 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 78.5 продицмиллээр өссөн байна.

**ГЭМТ ХЭРЭГ:** 2016 оны эхний хагас жилийн байдлаар дүүрэгт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо 152 байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар буюу 7 хэргээр буурсан байна. Мөн хэрэг илрүүлэлт 60.8 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.3 пунктээр нэмэгдсэн байна.



Хүснэгт 13. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	Хэргийн тоо		Хэргийн өсөлт	Дүнд эзлэх хувь
	2015 он	2016 он		
Хүний амь	1	1	-	0.7
Хүчин	2	5	3	3.3
Дээрэм	1	1	-	0.7
Танхай	7	8	1	5.3
ББМГУчруулах	72	63	-9	41.4
Ашиглах	3	2	-1	1.3
Хулгай	34	32	-2	21.1
<i>үүнээс: малын</i>	<i>4</i>	<i>-</i>	<i>-4</i>	<i>- *</i>

Булаалт	-	-	-	-
Залилан	7	7	-	4.6
ХАБЭсрэг	6	14	8	9.2
Гал түймэр	-	-	-	-
Бусад	26	19	-7	12.5
Бүгд	159	152	-7	100.0
Хэрэг илрүүлэлт	57.5%	60.8%		

\*- малын хулгайн хэргийг нийт хулгайн хэрэгт эзлэх хувиар тооцсон.

Зураг 11. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн бүтцийг авч үзэхэд 41.4 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах /ББМГУчруулах/ хэрэг, 21.1 хувийг хулгай хэрэг, 12.5 хувийг бусад гэмт хэрэг, 9.2 хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг /ХАБЭ/ гэмт хэрэг, 5.3 хувийг танхайн хэрэг, 4.6 хувийг залилангийн хэрэг, 3.3 хувийг хүчингийн хэрэг, 1.3 хувийг ашиглах гэмт хэрэг, 0.7 хувийг хүн амины хэрэг, 0.7 хувийг дээрмийн гэмт хэрэг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд булаалт, малын хулгай болон гал түймрийн хэргүүд бүртгэгдээгүй байна.

Хүснэгт 14. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2015 он		2016 он	
	согтуугаар	гудамж талбайд	согтуугаар	гудамж талбайд
Хүний амь	1	1	1	-
Хүчин	1	-	3	-
Дээрэм	1	-	-	-
Танхай	4	5	6	3
ББМГУчруулах	39	15	35	21
Хулгай	1	5	2	3
Залилан	1	-	-	-
ХАБЭсрэг	3	-	1	2
Бусад	7	7	4	8
Бүгд	58	33	52	37
Дүнд эзлэх хувь	36.4	20.7	34.2	24.3

Зураг 12. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг



2016 оны эхний хагас жилийн байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 52 болж өнгөрсөн оны мөн үеэс 10.3 хувиар буюу 6 хэргээр буурсан нь нийт гэмт хэргийн 34.2 хувийг эзэлж байгаа бөгөөд гэмт хэрэгт эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2.2 пунктээр буурсан байна. Харин гудамж талбайд үйлдэгдсэн хэргийн тоо 37 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 12.1 хувиар буюу 4 хэргээр өссөн бөгөөд


бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 24.3 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3.6 пунктээр нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд гэмт хэрэгт 167 иргэн холбогдон шалгагдсаны 7.7 хувь буюу 13 нь 18 хүртэлх насны хүүхэд, 15.5 хувь буюу 26 нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 15. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүс

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2015 он	2016 он	тоо	хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	167	149	-18	-10.8
Үүнээс: эмэгтэйчүүд	26	22	-4	-15.4
хүүхэд	13	5	-8	-61.5
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	175	160	-15	-8.6
Үүнээс: нас барсан	4	8	4	2.0 дахин их
гэмтсэн	94	94	-	-
Саатуулагдсан хүний тоо	790	868	78	9.9
Учирсан хохирол /сая төгрөг/	169.7	147.6	-22.1	-13.0
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	49.3	52.6	3.3	6.7

Зураг 13. Гэмт хэрэгт холбогдсон иргэд




2016 оны эхний хагас жилийн байдлаар гэмт хэргийн улмаас 160 хүн хохирсон ба үүнээс 94 хүн гэмтэж, 8 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс нас барсан хүний тоо 2 дахин их буюу 4 хүнээр өссөн байна. Тайлант хугацаанд 868 хүн саатуулагдсан нь өнгөрмөн оны мөн үеэс 9.9 хувиар буюу 78 хүнээр нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас 147.6 сая төгрөгийн хохирол учирсны 99.0 хувь нь буюу 146.1 сая төгрөг нь иргэдэд, 1.0

хувь буюу 1.5 сая төгрөг нь ААНБайгууллагад учруулсан хохирол байна. Нийт хохирлын 35.6 хувийг буюу 52.6 сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.

**АЖИЛ ЭРХЛЭЛТ:** 2016 оны 6 сарын байдлаар дүүрэгт ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 602 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 46.1 хувиар буюу 190 хүнээр, эмэгтэй ажилгүй иргэд 310 байгаа нь өмнөх оны мөн үеэс 30.8 хувиар буюу 73 хүнээр тус тус өссөн байна.


Зураг 14. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн



Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа 80 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүний 37.5 хувь нь буюу 30 нь эмэгтэйчүүд байна.

Тайлант сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа иргэдийн 135 буюу 22.4 хувь нь 16-24 насны ажилгүй иргэд, 233 буюу 38.7 хувь нь 25-34 насны ажилгүй иргэд, 149 буюу 24.8 хувь нь 35-44 насны ажилгүй иргэд, 85 буюу 14.1 хувь нь 45-аас дээш насны ажилгүй иргэд байна.

Зураг 15. Бүртгэлтэй ажилгүй иргэд /насны бүлгээр/



Зураг 16. Бүртгэлтэй ажилгүй иргэд /боловсролоор/




Ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр ангилж үзэхэд 26.7 хувийг дээд, 9.6 хувийг тусгай дунд, 10.8 хувийг мэргэжлийн анхан шатны, 44.2 хувийг бүрэн дунд, 5.2 хувийг бүрэн бус дунд, 2.5 хувийг бага боловсролтой, 1.0 хувийг боловсролгүй ажилгүй иргэд эзэлж байна.

ҮНЭ ХАНШ: 2016 оны 6 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.


Хүснэгт 16. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2016 оны 6 сарын дундаж үнэ

№	Хүнсний бараа	х.н	Хишиг-Уул супермаркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	В&М супермаркет	Шинэ хүнсний зах
1	"Алтан тариа" гурил	Дээд	кг	1350	1300	1300	1300
		I зэрэг	кг	1100	1100	1100	1100
		II зэрэг	кг	900	800	900	900
2	Будаа	цагаан	кг	2300	2100	2200	2300
		шар	кг	1600	1600	1700	1700
3	Хонины мах	ястай	кг			6813	6875
		цул	кг			7763	7763
4	Үхрийн мах	ястай	кг			8188	8375
		цул	кг			9063	9188
5	Адууны мах, ястай	кг			6188	6250	
6	Ямааны мах	кг			5688	5688	
7	Элсэн чихэр	кг	1700	1500		1500	1600
8	Сүү	л	800				
9	Тараг	л	900				
10	Цэцгийн тос, Орос	кг	3000	3000		3000	
11	Байцаа	кг			1438	1438	1438
12	Манжин	кг			3325	3325	3325
13	Төмс	монгол	кг		1175	1175	1175
14	Лууван	монгол	кг		2800	2800	2800
15	Сонгино	хятад	кг		1300	1300	1300
		монгол	кг		2687	2688	2688
16	Сармис, булцуу	кг			300	300	300
17	Огурцы, хятад	кг			4625	4625	4625
18	Помидор, хятад	кг			4875	4875	4875
19	Ургамлын тос/ sunny gold/	ш	3500	3500		3500	3500
20	Өндөг	ш	300	283		300	300
21	Талх	том 900 гр	ш	1600	1600	1600	1600
		Дунд 700 гр	ш	1400	1300	1400	1300
		жижиг 500 гр	ш	1100	1000	1000	1000
		Есөн шанд /жижиг/	ш	1600	1500	1600	1500
		Атар талх	ш	1150	1100	1200	1100

Зураг 17. "Алтан тариа" гурилын үнэ /жил бүрийн 6 сар/



Зураг 18. Нэг кг махны үнэ /жил бүрийн 6 сар/



Хүснэгт 17. Үйлчилгээний үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Үзүүлэлт	Айл өрхөд	Аж ахуйн нэгж байгууллагад
Дулаан	1 м <sup>2</sup> = 600 төг	1м <sup>3</sup> = 983 төг
Дулааны суурь тариф	40 м <sup>2</sup> хүртлэх= 3000 төг	-
	40м <sup>2</sup> - 80м <sup>2</sup> = 5000 төг	
	81м <sup>2</sup> –аас дээш = 10000 төг	
Халуун ус	Өвөл 1 хүн=2875 төг /тоолуургүй/ 1м <sup>3</sup> =1484 төг /тоолууртай /	1гкал= 62745 төг
	Зун 1 хүн=4025 төг /тоолуургүй/ 1м <sup>3</sup> =1484 төг /тоолууртай /	
Цэвэр ус*	1 л=0.8 төг /тоолуургүй/	1 л=1.50 төг /тоолуургүй/
	1 л=0.65 төг /тоолууртай/	1 л=1.20 төг /тоолууртай/
	Суурь хураамж =1800 төг	1 л=5.45 төг /зөөврөөр/
Бохир ус*	1 л=0.77 төг /тоолуургүй/	1 л=1.50 төг /тоолуургүй/
	1 л=0.63 төг /тоолууртай/	1 л=1.20 төг/тоолууртай/

\*2016 оны 2 сарын 1-нээс мөрдөж байгаа тариф

Хүснэгт 18. Цахилгааны үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
<i>* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф</i>		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	98.4
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	118.2
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	104.3
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	77.1
Сарын суурь тариф	төг/сар	2000.0
<i>* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф</i>		
Энгийн тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	128.5
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	209.8
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1

3 тарифт тоолууртай /уул уурхай, үйлдвэрийн газар/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	155.9
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	276.0
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1

\* 2015 оны 7 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй тариф

**Хүснэгт 19. Түлш шатахууны үнэ**

Шатахууны нэр төрөл	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	өөрчлөлт	
						хувь	төгрөгөөр
АИ -76,80	1505	1570	1560	1560	1490	4.4	-70
АИ -92,93	1805	1710	1700	1700	1600	5.8	-100
Дизель түлш	1855	1840	1830	1830	1710	7.0	-120

2016 оны 6 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд литр тутумдаа Аи-80 бензин 4.4 хувиар буюу 70 төгрөгөөр, Аи-92 бензин 5.8 хувиар, дизель түлш 7.0 хувиар буюу 120 төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг 19. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ /УБ-БН, БН-УБ/



**СТАТИСТИКИЙН ТАСАГ**

2016 оны 7 дугаар сарын 8 өдөр